



МОНГОЛ УЛСААС ЯПОН УЛС РУУ НЭВТРЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ковид-19



- 2022 оны **9 дүгээр сарын 7-ны** өдрөөс эхлэн Япон Улсад **хүчинтэйд** тооцогдож буй **вакцины** (Pfizer, Moderna) **3 удаагийн тунд** хамрагдсан гэрчилгээтэй иргэд нислэгээс өмнө **шинжилгээ** өгөх **шаардлагагүй**.

Зөвшөөрөгдсөн вакцины гэрчилгээнд тавигдах шаардлагын мэдээллийг https://www.mn.emb-japan.go.jp/itpr_ja/vaccinetuikamn.html холбоосоор авна уу.

- Япон Улсад хүчинтэйд тооцогдож буй вакцинд хамрагдаагүй зорчигчид Монгол Улсын хилээр гарахаас **72 цагийн өмнө** хийлгэсэн **PCR** шинжилгээний **сөрөг** гарсан хариуг Япон Улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны маягт дээр бөглүүлсэн байх шаардлагатай.

Шинжилгээний тодорхойлолтын маягтыг <https://www.mhlw.go.jp/content/000799426.pdf> холбоосоор татаж авна уу.



- “**MySOS**” аппликейшнийг <https://www.hco.mhlw.go.jp/fasttrack/en/> холбоосоор татан авч, шинжилгээний хариуг Япон Улсад ирэхээс өмнө оруулсан байна.



- Шинэ төрлийн коронавирусын **3 удаагийн вакцин** хийлгэсэн бөгөөд хүчинтэйд тооцсон вакцины гэрчилгээтэй бол **тусгаарлагдах шаардлагагүй**.
- Шинэ төрлийн коронавирусын 3 удаагийн **вакцин хийлгээгүй** тохиолдолд **гэр болон зочид буудал** зэрэгт **7 хоног тусгаарлагдах** шаардлагатай. Тусгаарлалтын **3 дахь өдрөө** өөрийн хүсэлтээр **шинжилгээ өгч** хариу **сөрөг** гарсан бол гэр болон зочид буудалд **тусгаарлагдахыг шаардахгүй**.

Дэлгэрэнгүй мэдээллийг https://www.mn.emb-japan.go.jp/itpr_ja/coviduurchlult.html холбоосоор орж авна уу.